**ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Орхон аймгийн ерөнхий боловсролын арван гуравдугаар сургуулийн 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ОРА-2026/029/НА-СТА-ТШЗ**

| | |
|---|---|
| Цахим хуудас: www.audit.mn<br>Эрдэнэт хот<br>2025 он | Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: П.Пүрэвлхагва<br>Утас: 70353088 Цахим хаяг: ppurevlkhagva@gmail.com<br><br>Аудитын менежер: Б.Буян-Ундрах<br>Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn<br><br>Аудитор: “Төгс нотолгоо аудит” ХХК-ийн Ахлах аудитор: Г.Цэцэгмаа<br>Утас: 99889665 Цахим хаяг: tugsnotolgooaudit@gmail.com |

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Нутгийн удирдлагын ордон, Эрх чөлөөний өргөн чөлөө-3,
Уртбулаг баг, Баян-Өндөр сум, Орхон аймаг, 61033
Утас: (976) 7035 9826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2026. 02.07 № 24
танай ______________-ны № ______________-т

ОРХОН АЙМГИЙН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН АРВАН ГУРАВ ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ М.БАТТӨР ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Орхон аймгийн 13 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн 13 дугаар сургуулийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Боловсролын ерөнхий газрын зөвшөөрлөөр 84,997.0 мянган төгрөгийн өртөгтэй англи хэл, математикийн иж бүрэн кабинетийн хэрэглэгдэхүүнийг "Мэксим Консалтинг" ХХК-аас 4 жилийн хугацаатайгаар эргэн төлөх нөхцөлтэй авсан байна. Эхний жилийн төлбөр болох 7,083.8 мянган төгрөгийг тайлант хугацаанд барагдуулж, 77,913.9 мянган төгрөгийн өр төлбөр нэмж үүсгэсэн байна.

Цаашид тус байгууллагын чиг үүрэг өөрчлөгдөж, татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар тодорхой бус байдал үүсээгүй байна.

**Аудитын гол асуудал**

Боловсролын салбарын байгууллагууд 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрөөс эхлэн 13 хоногийн ажил хаялтад нэгдэж, Хөдөлмөрийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 30.3-т “Ажил хаялтад оролцоогүй боловч түүнээс шалтгаалан ажил үүргээ гүйцэтгэх боломжгүй байсан ажилтанд тухайн хугацаанд дундаж цалин хөлстэй тэнцэх хэмжээний олговрыг ажил олгогч олгоно” гэж заасны дагуу цалин хөлсөө авсан байна.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын 2025 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, 79 арга хэмжээг хэрэгжүүлэхээр  Боловсрол, шинжлэх ухааны газрын даргатай байгуулж, хэрэгжилтийг тайлант онд  үнэлүүлээгүй байна.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт, тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбоотой холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР П.ПҮРЭВЛХАГВА

## ХОЁР. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Данс | Балансын зүйл | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 31 | МӨНГӨН ХӨРӨНГӨ | 297,476,323.52 | 80,509,885.73 |
| 312 | Банкинд байгаа бэлэн мөнгө | 297,476,323.52 | 80,509,885.73 |
| 3121 | Төгрөг | 297,476,323.52 | 80,509,885.73 |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 297,476,323.52 | 80,509,885.73 |
| 33 | АВЛАГА | | |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 286,618,179.77 | 295,193,788.13 |
| 351 | Түүхий эд материал | 209,679,631.31 | 189,609,077.61 |
| 3511 | Тусгай зориулалттай материал | 209,564,031.31 | 189,609,077.61 |
| 3513 | Эм боох материал | 115,600.00 | |
| 352 | Дуусаагүй үйлдвэрлэл | | 665,900.00 |
| 354 | Хангамжийн материал | 76,938,548.46 | 104,918,810.52 |
| 3541 | Бичиг хэргийн материал | 90,000.00 | |
| 3546 | Хүнсний материал | 1,499,684.00 | 1,507,820.00 |
| 3547 | Бусад хангамжийн материал | 75,348,864.46 | 103,410,990.52 |
| 36 | НӨӨЦИЙН БАРАА | 513,370.00 | |
| 361 | Барааны нөөц | 513,370.00 | |
| I | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 584,607,873.29 | 375,703,673.86 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 7,124,139,520.98 | 6,996,383,496.20 |
| 392 | Биет хөрөнгө | 6,253,436,913.78 | 6,131,063,690.60 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 6,268,154,647.20 | 6,268,154,647.20 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -809,390,250.91 | -948,351,905.86 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 715,051,695.25 | 827,929,431.25 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -210,375,806.17 | -317,380,257.32 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 380,303,097.13 | 421,725,417.13 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -123,314,546.19 | -138,078,955.26 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | 214,355,049.74 | 214,355,049.74 |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | -181,346,972.27 | -197,289,736.28 |
| 393 | Биет бус хөрөнгө | 870,702,607.20 | 865,319,805.60 |
| 39301 | Програм хангамж | 36,494,008.00 | 36,494,008.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -12,271,400.80 | -17,654,202.40 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 846,480,000.00 | 846,480,000.00 |
| II | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 7,124,139,520.98 | 6,996,383,496.20 |
| III | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 7,708,747,394.27 | 7,372,087,170.06 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 58,681,250.00 | 119,886,467.00 |
| 413 | Өглөг | 58,681,250.00 | 119,886,467.00 |
| 4136 | Бусад өглөг | 58,681,250.00 | 119,886,467.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 58,681,250.00 | 119,886,467.00 |
| IV | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 58,681,250.00 | 119,886,467.00 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 7,650,066,144.27 | 7,252,200,703.06 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 846,480,000.00 | 846,480,000.00 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,832,649,858.94 | 1,434,784,417.73 |
| 5121 | Өмнөх үеийн үр дүн | 1,832,649,858.94 | 1,832,649,858.94 |
| 5122 | Тайлант үеийн үр дүн | | -395,916,441.21 |
| 513 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 4,970,936,285.33 | 4,970,936,285.33 |
| V | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 7,650,066,144.27 | 7,252,200,703.06 |
| VI | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 7,708,747,394.27 | 7,374,036,170.06 |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,741,365,100.00 | 4,221,656,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,589,405,900.00 | 4,087,733,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,589,405,900.00 | 4,087,733,400.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 151,959,200.00 | 133,922,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 151,959,200.00 | 133,922,800.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 840,153,589.28 | 737,369,051.06 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 840,153,589.28 | 737,369,051.06 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 345,886,828.00 | 536,367,175.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,065,700.00 | 14,914,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 330,821,128.00 | 521,452,675.00 |
| 120009 | Бусад орлого | 48,020,550.00 | 113,558,500.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | 405,690,899.48 | 39,404,000.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал | 40,555,311.80 | 49,988,376.06 |
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 4,581,518,689.28 | 4,960,974,251.06 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 4,306,114,887.65 | 5,356,555,050.42 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 4,099,007,004.45 | 5,078,545,678.63 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,874,903,146.06 | 3,653,868,510.66 |
| 210101 | Үндсэн цалин | 1,736,475,241.63 | 2,097,303,366.02 |
| 210102 | Нэмэгдэл | 1,000,830,466.16 | 1,346,288,734.50 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,914,800.00 | 100,271,972.83 |
| 210104 | Урамшуулал | 135,682,638.27 | 110,004,437.31 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 352,027,553.44 | 450,078,918.97 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 239,861,914.55 | 309,501,047.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 29,176,263.45 | 37,019,473.26 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,980,825.67 | 18,854,462.87 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 13,605,956.29 | 16,861,384.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 54,402,593.48 | 67,842,551.05 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 88,822,332.80 | 108,118,492.21 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,706,636.64 | 35,892,713.93 |
| 210302 | Түлш, халаалт | 41,882,461.14 | 40,837,130.85 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 21,233,235.02 | 31,388,647.43 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 71,728,720.06 | 159,667,703.70 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 48,020,550.00 | 113,558,500.00 |
| 210408 | Бараа материал акталсны зардал | 23,708,170.06 | 46,109,203.70 |
| 2105 | Нормативт зардал | 107,278,200.00 | 57,584,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 107,278,200.00 | 57,584,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 53,710,000.00 | 20,430,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 53,710,000.00 | 20,430,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 50,498,139.83 | 79,388,611.66 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,088,700.00 | 14,914,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 35,409,439.83 | 64,474,111.66 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,038,912.26 | 549,409,441.43 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 147,185,347.61 | 194,108,293.50 |

| | | | |
|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 32,140,500.00 | 25,624,529.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 320,713,064.65 | 329,676,618.93 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 207,107,883.20 | 278,009,371.79 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 197,871,016.00 | 272,635,064.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 197,871,016.00 | 272,635,064.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 9,236,867.20 | 5,374,307.79 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,236,867.20 | 5,374,307.79 |
| II | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 4,306,114,887.65 | 5,356,555,050.42 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 275,403,801.63 | 395,916,441.21 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 3,409,658.72 | 335,641.85 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 3,409,658.72 | 335,641.85 |
| IV | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | -3,409,658.72 | -335,641.85 |
| V | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 271,994,142.91 | 395,916,441.21 |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Данс | Үзүүлэлт | Өмнөх он | Тайлант он |
|---|---|---|---|
| I | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 4,087,251,928.00 | 4,758,023,375.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 345,886,828.00 | 536,367,175.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 345,886,828.00 | 536,367,175.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 345,886,828.00 | 536,367,175.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,065,700.00 | 14,914,500.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 330,821,128.00 | 521,452,675.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 3,741,365,100.00 | 4,221,656,200.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 3,589,405,900.00 | 4,087,733,400.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 3,589,405,900.00 | 4,087,733,400.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | | |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 151,959,200.00 | 133,922,800.00 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 151,959,200.00 | 133,922,800.00 |
| 1340 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | |
| II | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 3,940,253,046.94 | 4,888,102,493.79 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,940,253,046.94 | 4,888,102,493.79 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,731,645,479.74 | 4,610,084,986.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 2,874,903,146.06 | 3,653,868,510.66 |
| 210101 | Үндсэн цалин | 1,736,475,241.63 | 2,097,303,366.02 |
| 210102 | Нэмэгдэл | 1,000,830,466.16 | 1,346,288,734.50 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 1,914,800.00 | 100,271,972.83 |
| 210104 | Урамшуулал | 135,682,638.27 | 110,004,437.31 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 352,027,553.44 | 450,078,918.97 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 239,861,914.55 | 309,501,047.79 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 29,176,263.45 | 37,019,473.26 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 14,980,825.67 | 18,854,462.87 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 13,605,956.29 | 16,861,384.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 54,402,593.48 | 67,842,551.05 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 88,822,332.80 | 108,118,492.21 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 25,706,636.64 | 35,892,713.93 |
| 210302 | Түлш, халаалт | 41,882,461.14 | 40,837,130.85 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 21,233,235.02 | 31,388,647.43 |

| | | | |
|---|---|---|---|
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | | |
| 2105 | Нормативт зардал | 107,278,200.00 | 57,584,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 107,278,200.00 | 57,584,000.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 53,900,000.00 | 20,430,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 53,900,000.00 | 20,430,000.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | | |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 50,498,139.83 | 79,388,611.66 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,088,700.00 | 14,914,500.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 35,409,439.83 | 64,474,111.66 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 204,216,107.61 | 240,616,452.50 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 172,075,607.61 | 214,991,923.50 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 32,140,500.00 | 25,624,529.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 208,607,567.20 | 278,017,507.79 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 199,370,700.00 | 272,643,200.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 199,370,700.00 | 272,643,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | | |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 9,236,867.20 | 5,374,307.79 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,236,867.20 | 5,374,307.79 |
| III | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 146,998,881.06 | -130,079,118.79 |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| IV | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4) | | |
| V | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 101,873,758.00 | 86,887,319.00 |
| | Дотоод эх үүсвэрээр | 101,873,758.00 | 86,887,319.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 101,873,758.00 | 86,887,319.00 |
| VI | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -101,873,758.00 | -86,887,319.00 |
| VIII | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 45,125,123.06 | -216,966,437.79 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | 297,476,323.52 |
| 31 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | 80,509,885.73 |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 846,480,000.00 | 4,970,936,285.33 | 1,560,655,716.03 | 7,378,072,001.36 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **846,480,000.00** | **4,970,936,285.33** | **1,560,655,716.03** | 7,378,072,001.36 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 271,994,142.91 | 271,994,142.91 |
| C08 | **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **846,480,000.00** | **4,970,936,285.33** | **1,832,649,858.94** | 7,650,066,144.27 |
| D01 | **2025 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **846,480,000.00** | **4,970,936,285.33** | **1,832,649,858.94** | 7,650,066,144.27 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **846,480,000.00** | **4,970,936,285.33** | **1,832,649,858.94** | 7,650,066,144.27 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (395,916,441.21) | (395,916,441.21) |
| D09 | **2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **846,480,000.00** | **4,970,936,285.33** | **1,436,733,417.73** | 7,254,149,703.06 |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант он | | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 5,047,084,600.00 | 4,888,102,493.79 | 158,982,106.21 | 32.52 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 5,047,084,600.00 | 4,888,102,493.79 | 158,982,106.21 | 32.52 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 4,763,896,900.00 | 4,610,084,986.00 | 153,811,914.00 | 33.36 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 3,802,277,400.00 | 3,653,868,510.66 | 148,408,889.34 | 40.62 |
| 210101 | Үндсэн цалин | 2,196,814,200.00 | 2,097,303,366.02 | 99,510,833.98 | 47.45 |
| 210102 | Нэмэгдэл | 1,532,980,200.00 | 1,346,288,734.50 | 186,691,465.50 | 138.67 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | - | 100,271,972.83 | (100,271,972.83) | (1,000.00) |
| 210104 | Урамшуулал | 72,483,000.00 | 110,004,437.31 | (37,521,437.31) | (341.09) |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 476,827,700.00 | 450,078,918.97 | 26,748,781.03 | 59.43 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 324,242,800.00 | 309,501,047.79 | 14,741,752.21 | 47.63 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 38,146,200.00 | 37,019,473.26 | 1,126,726.74 | 30.44 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 19,073,100.00 | 18,854,462.87 | 218,637.13 | 11.60 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 19,073,100.00 | 16,861,384.00 | 2,211,716.00 | 131.17 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 76,292,500.00 | 67,842,551.05 | 8,449,948.95 | 124.55 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 113,492,800.00 | 108,118,492.21 | 5,374,307.79 | 49.71 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 31,771,600.00 | 35,892,713.93 | (4,121,113.93) | (114.82) |
| 210302 | Түлш, халаалт | 58,187,400.00 | 40,837,130.85 | 17,350,269.15 | 424.87 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 23,533,800.00 | 31,388,647.43 | (7,854,847.43) | (250.24) |
| 210304 | Байрны түрээс | | | - | |
| **2105** | **Нормативт зардал** | 57,800,000.00 | 57,584,000.00 | 216,000.00 | 3.75 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | | | - | - |
| 210502 | Хоол, хүнс | 57,800,000.00 | 57,584,000.00 | 216,000.00 | 3.75 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 20,430,000.00 | 20,430,000.00 | - | - |
| 210604 | Урсгал засвар | 20,430,000.00 | 20,430,000.00 | - | - |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 84,510,200.00 | 79,388,611.66 | 5,121,588.34 | 64.51 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,001,000.00 | 14,914,500.00 | 86,500.00 | 5.80 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 69,509,200.00 | 64,474,111.66 | 5,035,088.34 | 78.09 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 342,481,600.00 | 240,616,452.50 | 101,865,147.50 | 423.35 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 316,857,000.00 | 214,991,923.50 | 101,865,076.50 | 473.81 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 25,624,600.00 | 25,624,529.00 | 71.00 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 283,187,700.00 | 278,017,507.79 | 5,170,192.21 | 18.60 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 283,187,700.00 | 278,017,507.79 | 5,170,192.21 | 18.60 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 283,187,700.00 | 272,643,200.00 | 10,544,500.00 | 38.68 |
| 213403 | Төвлөрүүлэх шилүүлэг | | 5,374,307.79 | (5,374,307.79) | (1,000.00) |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **86,887,319.00** | (86,887,319.00) | (1,000.00) |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | 86,887,319.00 | (86,887,319.00) | (1,000.00) |
| 222001 | Тоног төхөөрөмж | - | 86,887,319.00 | (86,887,319.00) | (1,000.00) |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 5,181,007,400.00 | 4,758,023,375.00 | 126,069,625.00 | 26.50 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 4,095,187,200.00 | 4,087,733,400.00 | 7,453,800.00 | 1.82 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 4,095,187,200.00 | 4,087,733,400.00 | 7,453,800.00 | 1.82 |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 133,922,800.00 | 133,922,800.00 | - | - |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 133,922,800.00 | 133,922,800.00 | - | - |
| **120004** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГО** | 951,897,400.00 | 536,367,175.00 | 118,615,825.00 | 221.15 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 15,001,000.00 | 14,914,500.00 | 86,500.00 | 5.80 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 639,982,000.00 | 521,452,675.00 | 118,529,325.00 | 227.31 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 296,914,400.00 | | | |
| **4** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **297,476,323.52** | (297,476,323.52) | (1,000.00) |
| **5** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | | **80,509,885.73** | (80,509,885.73) | (1,000.00) |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 2.00 | | |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 2.00 | | |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 119.00 | 119.00 | | |
| 620001 | Удирдах ажилтан | 1.00 | 1.00 | | |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 92.00 | 92.00 | | |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 26.00 | 26.00 | | |
| **630** | **ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД** | 2,019.00 | 2,019.00 | | |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 2,019.00 | 2,019.00 | | |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **119.00** | **119.00** | | |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 81.00 | 81.00 | | |
| 650006 | Соёл урлагийн салбарын төрийн їйлчилгээний албан хаагч (ТҮСУ) | 1.00 | 1.00 | | |
| 650008 | Эрүүл мэндийн салбарын төрийн үйлчилгээний албан хаагч (ТҮЭМ) | 1.00 | 1.00 | | |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 36.00 | 36.00 | | |

Аудитаар нийт 20,006.2 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 20,006.2 мянган төгрөгийн алдааг залруулж тайлагнасан.

***Залруулсан алдаа:***
Санхүүгийн үр дүнгийн тайланд актлсан бараа материалыг 20, 006.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

Аудитаар нийт 32,867.0 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс, 7,150.1 мянган төгрөгийн зөрчилд 4 төлбөрийн акт тогтоож, 24,122.2 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлж, 1,594.7 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгсөн.

**3.1 Төлбөрийн акт**

Сургалтын үйл ажиллагаа явуулаагүй байхад 8 дугаар сард албан хаагчид 1,257.8 мянган төгрөгийн анги даасны нэмэгдэл хөлс олгосон, 1 албан хаагчийн цалинг ээлжийн амралтын цалинтай давхардуулан 70.2 мянган төгрөг илүү олгосон, санхүүгийн программын сургалтын зардал болон албан томилолтын зардалд 400.0 мянган төгрөгийг зарцуулсан, сургуулийн хоолны газарт хоол борлуулж орлогоо 5,422.1 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн

**3.2 Албан шаардлага**

Наймаа толгой" ХХК-тай гэрээ байгуулж дотоод сүлжээ, хяналтын камерын тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл суурилуулах, тохируулах, засварлах ажил бүрэн хийгдээгүй, ажлыг хүлээж аваагүй байхад 9,896.0 мянган төгрөгийг шилжүүлж зардлаар тайлагнасан, сурагчдын үдийн хоолонд хамрагддаг бага ангийн 20 багш, 1 хоол зүйчид олгосон жилийн хоолны хөнгөлөлтийн олговор 10,077.0 мянган төгрөгөөр давхардуулан олгосон, тайлант онд сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын 4,149.2 мянган төгрөгийн зарцуулах ажлын хэсэг байгуулаагүй, хамт олноор хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл байхгүй төсвийг хяналтгүй үр ашиггүй зарцуулсан зөрчлүүдэд 3 албан шаардлага хүргүүлсэн.

**3.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Нягтлан бодох бүртгэлийн тайлагналтай холбоотой

***<u>Илрүүлэлт</u>:***

Хүнсний бараа материалын тайланг эд хариуцагчийн материалын тайлангийн зарлагаас 1,594.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.7-т "байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах", 20 дугаар зүйлийн 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах;- заалтыг тус тус зөрчсөн байна.

---

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

***<u>Өгсөн зөвлөмж</u>*:**

Нягтлан бодох бүртгэлийг холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан журам, зааврын дагуу хөтөлж байх.

<u>2. Хөрөнгийн тооллоготой холбоотой асуудал</u>

***<u>Илрүүлэлт:</u>***

Батлагдсан анхан шатны маягтын дагуу жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогыг хийгээгүй байна

Энэ нь Сангийн сайдын 2017 оны 12 дугаар сарын 05-ны 347 дугаар тушаалын хавсралт "Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар" НХМаягт БМ-8 Эд хөрөнгийн тооллогын бүртгэл "Аж ахуйн нэгж, байгууллагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасны дагуу тооллогыг явуулна. Тооллогын комисс эд хөрөнгийн тооллогыг тогтоосон хугацаанд зааврын дагуу үнэн зөв, чанартай явуулж тооллогын явц үр дүнг комиссын хурлаар хэлэлцэж, тооллогын бүртгэлийг 2 хувь үйлдэж байгууллагын удирдлагад танилцуулан батлуулж, санхүүгийн албанд хүргүүлэх үүрэгтэй" НХМаягт БМ-9 " Бараа материалын тайланг агуулахын нярав, эд хариуцагч нь аж ахуйн нэгж, байгуулагын бүртгэлийн бодлогын баримт бичигт заасан хугацаанд агуулахын бүртгэлд үндэслэн материалын нэр төрөл тус бүрийн тоо хэмжээгээр нэгтгэн гаргана. Бараа материалын тайланг нярав, эд хариуцагч нар дээр хөтлөгдөж буй агуулахын бүртгэлтэй тулган шалгаж хүлээж авна" гэж заасныг зөрчсөн байна.

***<u>Өгсөн зөвлөмж:</u>***

Хөрөнгийн тооллогыг батлагдсан маягтын дагуу хийж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## ДӨРӨВ. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Санхүүгийн үр дүнгийн тайланд акталсан бараа материалыг 20, 006.2 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан | 1 | 20,006.2 | | | | 20,006.2 | 1 | 20,006.2 | | | | |
| **Дүн** | **1** | **20,006.2** | | | | **20,006.2** | **1** | **20,006.2** | | | | |

### ТАВ. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Албан тушаалтны тоо | Тоо | Дүн |
| Сургалтын үйл ажиллагаа явуулаагүй байхад 8 дугаар сард албан хаагчид 1,257.8 мянган төгрөгийн анги даасны нэмэгдэл хөлс олгосон | 1 | 1,257.8 | 1 | 1,257.8 | | | | | | | | |
| Албан хаагчид ээлжийн амралтын цалинг давхардуулан 70.2 мянган төгрөгийн цалин илүү олгосон | 1 | 70.2 | 1 | 70.2 | | | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Сургуулийн хоолны газарт хоол борлуулж орлогоо 5,422.1 мянган төгрөгөөр дутуу төвлөрүүлсэн | 1 | 5,422.1 | 1 | 5,422.1 | | | | | | | | |
| Анхан шатны баримтгүй 400.0 мянган төгрөгийн томилолтын зардал олгосон. | 1 | 400.0 | 1 | 400.0 | | | | | | | | |
| Сурагчдын үдийн хоолонд хамрагддаг бага ангийн 20 багш, 1 хоол зүйчид олгосон жилийн хоолны хөнгөлөлтийн олговор 10,077.0 мянган төгрөгөөр давхацсан байна. | 1 | 10,077.0 | | | 1 | 10,077.0 | | | | | | |
| "Наймаа толгой" ХХК-тай гэрээ байгуулж дотоод сүлжээ, хяналтын камерын тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл суурилуулах, тохируулах,засварлах ажил бүрэн хийгдээгүй, ажлыг хүлээж аваагүй байхад 9,896.0 мянган төгрөгийг шилжүүлж зардлаар тайлагнасан | 1 | 9,896.0 | | | 1 | 9,896.0 | | | | | | |
| Тайлант оны эцэст сургалтын хэвийн үйл ажиллагааг хангах багшийн мэргэжил дээшлүүлэх сургалтын 4,149.2 мянган төгрөгийн зарцуулах ажлын хэсэг байгуулаагүй, хамт олноор хэлэлцүүлсэн хурлын тэмдэглэл байхгүй төсвийг хяналтгүй үр ашиггүй зарцуулсан | 1 | 4,149.2 | | | 1 | 4,149.2 | | | | | | |
| Нягтлан бодох бүртгэлийн хүнсний бараа материалын зарлага эд хариуцагчийн материалын тайлангийн зарлагаас 1,594.7 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан | 1 | 1,594.7 | | | | | 1 | 1,594.7 | | | | |
| Үндсэн хөрөнгө, бараа материалын хөрөнгийн тооллогыг батлагдсан анхан шатны маягтаар хийгээгүй | 1 | | | | | | 1 | 0 | | | | |
| **Дүн** | **9** | **32,867.0** | **4** | **7,150.1** | **3** | **24,122.2** | **2** | **1,594.7** | | | | |

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |

| | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | | |
| | | - | | | | | | | - |
| **Дүн** | | **-** | | | | | | | **-** |
| **Нийт дүн** | | **-** | | | | | | | **-** |